



ГОВЬСҮМБЭР АЙМАГ
ШИВЭЭГОВЬ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 04 сарын 14 өдөр

Дугаар 1167

Шивээговь сум

0-12 насны хүүхэдтэй ажилтан, албан
хаагчдад цалинтай чөлөө олгох тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Засгийн газрын 2020 оны 02 дугаар сарын 19-ний өдрийн “Бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацааг сунгах тухай” 64 дүгээр тогтоол, аймгийн Засаг даргын 2020 оны 04 дүгээр сарын 13-ны өдрийн А/124 дугаар “Зохион байгуулалтын арга хэмжээ авах тухай” захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. Коронавируст халдвар тархахаас урьдчилан сэргийлэх, бага насны хүүхдийн аюулгүй байдлыг хангах зорилгоор 2020 оны 04 дүгээр сарын 14-ний өдрөөс 04 дүгээр сарын 30-ны өдрийг дуустал хугацаанд жирэмсэн болон 0-12 насны хүүхэдтэй эмэгтэй ажилтан, албан хаагчийг гэрээсээ ажиллах нөхцөл боломжоор хангаж, цалинтай чөлөө олгох зэрэг арга хэмжээ авч ажиллахыг сумын хэмжээнд үйл ажиллагаа явуулдаг төрийн болон орон нутгийн өмчит газар, аж ахуйн нэгжийн удирдлагуудад зөвшөөрсүгэй.

2. Дээрх зохицуулалттай холбогдуулан байгууллагын хэвийн үйл ажиллагааг алдагдуулахгүйгээр зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллахыг байгууллагын удирдлагуудад үүрэг болгосугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч, онцгой комиссын гишүүн /Ж.Батмөнх/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



С.ЯГААНЦЭЦЭГ

D:\My Documents\zaxiramj.doc

4212 174